**ХҮНИЙ ПАПИЛЛОМА ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНААР ДАРХЛААЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРЧИМЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДАД СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.**

Монгол Улсын Эрүүл мэндийн яам, Боловсролын яамны сайдын хамтарсан 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/484, А/291 дүгээр тушаал Боловсролы сургалтыгн байгууллагад суурилсан дархлаажуулах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд **х**үний папиллома вирусийн халдварын эсрэг вакцины ач холбогдол, дархлаажуулалтын үр дүнгийн талаарх мэдээ, мэдээллийг зорилтот бүлгийн хүн амд бүлгийн уулзалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах ажлаар хөдөөгийн 13 сумдын зорилтот бүлгийн хүн амд бүлгийн уулзалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн хамт ХПВ-ийн эсрэг дархлаажуулалты байдалтай танилцаж, дэмжлэг үзүүлэх, нөлөөллийн үйл ажиллагааг суманд нь хүрч үйлчлэн үзүүлэх зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн хөдөөгийн 13 сумын ЗДТГ, ЕБС, ЭМТ-үүдэд ажиллав. Аймгийн 13 сумын хамрагдвал зохих 11 настай хүүхдүүдийн ХПВ-ийн эсрэг дархлаажуулалтын хамралтын хувь нөлөөллийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө 28.4 хувьтай байсан бол нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулан ажилласаны үр дүнд 11 настай хүүхдүүдийн ХПВ-ийн эсрэг дархлаажуулалтын хамралт 80.1 хувь болж нэмэгдсэн. Хөдөөгийн 13 сумдад хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалтын ач холбогдол, үр дүнгийн талаарх мэдээ, мэдээллийг танхимын хэлбэрээр нийт 1566 иргэнд түгээж ажилласан.



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, БОЛОВСРОЛЫН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 12 сарын 05 өдөр Дугаар А/484 А/231 Улаанбаатар хот

Боловсролын сургалтын байгууллагад суурилсан
дархлаажуулах үйл ажиллагааг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэг, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Боловсролын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.10 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 472 дугаар тогтоолыг тус тус үндэслэл ТУШААХ нь:

1. "Боловсролын сургалтын байгууллагад суурилсан дархлаажуулалтын зохион байгуулалт, цэгийн бэлэн байдлыг хангах заавар"-ыг хавсралтаар баталсугай.
2. Ерөнхий боловсролын сургуульд дархлаажуулалтын ажил зохион байгуулахад мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Э.Анхбаяр), боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалт, оролцоог хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т, тус тус даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газар (О.Энхболд), Боловсролын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Н.Нарангэрэл), Салбарын хяналтын газар (Л.Төгсбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД Т.МӨНХСАЙХАН

БОЛОВСРОЛЫН САЙД П.НАРАНБАЯР



ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
Чойбалсангийн гудамж, 7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21063, Утас/Факс: 7058-4830
Цахим шуудан: admin@dornod.moh.gov.mn
Цахим хуудас: www.dornod.moh.gov.mn

2025.03.28 № 3/162
танай ___ -ны № ___ -т

БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН ДАРГА
Ч.АРИУНАА ТАНАА

Хамтран ажиллах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 472 дугаар тогтоолоор "Дархлаажуулалтын үндэсний товлол"-д Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакциныг 11 настай хүүхдэд хийхээр шинэчлэн баталсан.

Үүний дагуу Эрүүл мэндийн сайдын А/455 дугаар тушаал гарч 2024 оны 11 дүгээр сараас орон даяар уг вакциныг нэвтрүүлэн ажиллаж байна.

Мөн Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын 2024оны А/484, А231 дүгээр хамтарсан тушаалын"Боловсролын сургалтын байгууллагад суурилсан дархлаажуулах үйл ажиллагааг зохион байгуулах" хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

Манай аймаг 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар ХПВ-ийн дархлаажуулалтын хамралт 40,1% байна.

Иймд вакцинжуулалтыг эрчимжүүлэх зорилгоор боловсролын байгууллагын удирдлага, багш нар, эцэг, эх, хүүхдүүдэд ухуулга нөлөөлөл үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатай байгаа тул бидний ажилд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана уу.

Хавсралтаар Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан А/484, А231 тушаал болон сургалтын хөтөлбөрийг хүргүүлэв.

Хавсралт 1 хуудастай

Хүндэтгэсэн,

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА П.БИБИШ

2025.03.27-ны/ний 3/162 тоотыг цахимаар шуудангаар хүргүүлэв.
Хөтлөх хэргийн № 129-т bichig A4

2106302050

Зураг 1- ЭМС, БС-ын А/484, А/231 тоот хамтарсан тушаал

Зураг 2-ЭМГ-ын 3/162 тоот бичиг

Дорнод аймгийн сургууль, цэцэрлэгийн арга зүйн зөвлөл




Зураг 6- Багш нарт зориулсан сургалт, нөлөөллийн үйл ажиллагааны явц




Зураг 7- Эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан сургалт, нөлөөллийн үйл ажиллагааны явц



Зураг 8- ЕБС-ийн 5,6-р ангийн суралцагчдад зориулсан сургалт, нөлөөллийн үйл ажиллагааны явц

Биологи, эрүүл мэндийн судлагдахуун хариуцсан

ахлах арга зүйч Э.Эрхэмтөгс

Утас:918988838 86239883

Имэйл хаяг: e.erkhemtugs@gmail.com

Эх сурвалж: Дорнод аймгийн сургууль, цэцэрлэгийн эмч нар пэйж хуудас

Дорнодын захирал, менежерүүд пэйж хуудас

Дорнодын цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйчид пэйж хуудас